



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/187

Булган

### Хөрөнгө гаргах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3, 29.1.3 /а/, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.5, 4.5.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1, 46.1.4, 46.1.5, 50.1.2, УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 1.4.5, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын 2.1.1, 2.1.3, Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 2.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Гуртын гүүр”-ийн мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын хэсгийн албаны хэрэгцээнд шаардлагатай автомашиныг худалдан авч олгосугай.

2. Хууль, журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, комисс байгуулан автомашиныг хүлээлцэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ч.Амгалан/-т даалгасугай.

3. Албан хэрэгцээнд ашиглах автомашиныг 10 000 000 /арван сая/ төгрөгт багтааж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ